



УВС АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# УВС АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР, 2012 ОНД

Улаангом хот

**Танилцуулгыг хянан, тохиосон:**

Статистикийн хэлтсийн дарга Ж. Эрдэнэсүрэн

**Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:**

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Г.Сувдаа

Хаяг: Увс аймгийн ЗДТГ-ын байр 117 тоот, Улаангом сум 3-р баг

Утас: 70452322, 70453316

Имэйл:[stat\\_uvs@yahoo.com](mailto:stat_uvs@yahoo.com) Веб хаяг: <http://nso.mn>, [www.1212.mn](http://www.1212.mn).

## АГУУЛГА

### Оршил

<b>I. Эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь</b>	<b>7</b>
<b>II. Мал аж ахуй</b>	<b>8</b>
II.1. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлт	
II.2. Малын 2012 оны тооллогын дүн	
II.2.1. Малтай болон малчин өрх, малчид, тэдгээрийн соёл ахуйн үзүүлэлтүүд	11
II.2.2. Мал, тэжээвэр амьтдын тоо, сүргийн бүтэц	
Малтай өрхийн бүлэглэлт	18
Малчин өрхийн бүлэглэлт	21
Хээлтэгч малын тоо	22
Төл бойжилт	23
Малын зүй бус хорогдол	25
Хээл хаялт, сувайралт	27
Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо	28
Малын хэрэглээний зарлага	29
Сүргийн бүтэц	30
II.2.3. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	32
II.2.4. Тэжээвэр амьтад	33
II.2.5. Худаг, хашааны тооллого	34
II.2.6. Малжуулах арга хэмжээний тайлан	35
<b>III. Газар тариалан</b>	
III.1. Тариалсан талбай	37
III.2. Газар тариалангийн хураасан ургац	39
Дүгнэлт	40
Хавсралтууд	40-72

## ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгдэж байдаг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай “ Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн газрын удирдамж заавраар мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2012 оны 12 сарын 7 -ноос 17 -ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулж, дүнг нэгтгэн 2012 оны 1 дүгээр сард холбогдох байгууллагуудад хүргүүлсэн болно.

Энэхүү танилцуулгад Увс аймгийн 2012 оны мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нэмэгдэл өртөг, мал аж ахуйн салбарт хэрэглэж буй хашаа, худаг, тэжээлийн хүрэлцээ хангамж болон шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Монгол Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах, мөн усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хөдөөгийн хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор малжуулах болон усжуулах арга хэмжээний үр дүнг нэгтгэн дүгнэх зорилгоор 2012 оны мал тооллоготой хамтруулан зохион байгуулан явууллаа.

Тооллогын дүнг бүсчилсэн байдлаар Баруун, Хойд, Өмнөд, Зүүн бүс болон Улаангом гэсэн ангилаллаар зэрэгцүүлэлт хийж гаргалаа.

Манай улсын түүний дотор Увс аймгийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга судалгаа суурь материал болно гэдэгт итгэж байна.

## ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх.** Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх  
**Малчин өрх.** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

**Малчид.** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

### Бодод шилжүүлэх коэффициент.

1 Адуу, үхэр = 1 бод, 1 тэмээ = 1.5 бод,  
6 хонь = 1 бод 8 ямаа = 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

### Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ = 5 хонь , 1 адуу = 7 хонь, 1 үхэр = 6 хонь  
1 хонь = 1 хонь , 1 ямаа = 0.9 хонь

Хонин толгойд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хэрэгцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

**Нас гүйцсэн мал.** Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай , 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

### **Өсвөр насны мал .**

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

**Төл мал.** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч.** Малын төрөл бүр дээр нас гүйцсэн /сүүлийн 2 насны/ эм малыг хэлнэ.

**Малын тоо, толгойн өсөлт.** Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана. Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

**Төллөлтийн хувь.** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлнэ.

**Бойжилтийн хувь.** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100 –гаар үржүүлнэ.

**100 эхээс бойжуулсан төл.** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур	-	20-25	Азарга	-	12-15
Бух	-	35-45	Хуц, ухна	-	25-30

**Малын зүй бус хорогдолд** өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь.** Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Малын хэрэглээний зарлага.**

1. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

**Малын хашааны хангамж.** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

**Тэжээл хангамж .** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент.** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг. Үүний тулд доорхи

Хадлан өвс –	0.45
Таримал тэжээл -	0.35
Даршны ургамал -	0.25
Гар тэжээл, хужир шүү -	1.0
Төмс ногооны хаягдал -	0.22
Үр тарианы хаягдал -	0.9
Лай -	0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

**Малын тэжээлийн ангилал.** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
  1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
  2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
  3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн мах, яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

**Эдийн засгийн бүсэд:**

**Баруун бүсийн сумууд** – Тариалан, Ховд, Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь

**Хойд бүс** – Сагил, Давст, Түргэн, Бөхмөрөн

**Өмнөд бүс** – Баруунтуруун, Цагаанхайрхан, Зүүнхангай, Өндөрхангай

**Зүүн бүс** – Тэс, Зүүнговь, Хяргас, Малчин

**Төвийн бүс** - Улаангом сум

### I. ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас ихээхэн хамааралтай бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийг явуулахад гол түүхий эд болдог онцлогтой. 2012 оны байдлаар манай аймгийн ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн)-ий урьдчилсан байдлаар 49.0 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байна.



\*- урьдчилсан гүйцэтгэл

2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр аймгийн хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 74412.8 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 52.7 хувь буюу 25673.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

## II. МАЛ АЖ АХУЙ

### II.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 74.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр 52.7 хувиар өсчээ.

Мал аж ахуйн салбарт 2012 онд нядалгааны жингээр 9169.6 тонн мах, 19937.7 тонн сүү, 1095.0 тонн хонины ноос, 256.1 тонн ноолуур, 57.9 тонн тэмээний ноос, 224.0 мянган ширхэг арьс, шир үйлдвэрлэв. Өмнөх оныхтой харьцуулахад махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр 1616.2 тонн, сүүний үйлдвэрлэл 2100, ноолуур 38.7, хонины ноос 95.9, тэмээний ноос 3.5 тонноор өсч, арьс, шир 180.6 мянган ширхэгээр буурсан байна (Хүснэгт 2).

#### Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр

	2010	2011	2012	2012/2011	
				хувь	Зөрүү
<b>Мах, нядалгааны жингээр, тонн</b>	<b>7497.3</b>	<b>7553.4</b>	<b>9169.6</b>	<b>121.4</b>	<b>1616.2</b>
Адууны	133.2	586.0	877.0	149.7	291.0
Үхрийн	1384.4	1538.0	2277.6	148.1	739.6
Тэмээний	299.2	192.9	302.9	157.0	110.0
Хонины	3929.9	3666.4	3308.0	90.2	-358.4
Ямааны	1749.6	1568.5	2402.6	-153.1	834.1
<b>Сүү, тонн</b>	<b>12340.6</b>	<b>17837.7</b>	<b>19937.7</b>	<b>111.8</b>	<b>2100.0</b>
Гүүний	1007.1	1749.3	1911.7	109.2	162.4
Үнээний	9489.8	12164.1	14160.1	116.4	1996.0
Ингэний	141.0	196.6	246.5	125.3	49.9
Хонины	1038.6	1178.7	1201.5	101.9	22.8
Ямааны	664.0	2549.0	2417.9	94.8	-131.1
<b>Ноос, ноолуур, т</b>	<b>1921.1</b>	<b>1328.2</b>	<b>1474.7</b>	<b>111.0</b>	<b>146.5</b>
Тэмээний ноос	59.7	54.4	57.9	106.4	3.5
Хонины ноос	1472.6	999.1	1095.0	109.6	95.9
Ямааны ноолуур	311.4	217.4	256.1	117.8	38.7
<b>Арьс, шир, м.ш</b>	<b>1061.5</b>	<b>404.6</b>	<b>224.0</b>	<b>55.3</b>	<b>-180.6</b>
Тэмээний	2.1	6.2	0.4	6.5	5.8
Адууны	10.7	14.4	4.0	27.8	-10.4
Үхрийн	29.8	1.0	8.3	8.3	-7.3
Хонины	439.7	213.7	92.5	43.3	-121.2
Ямааны	296.7	127.6	83.3	65.2	-44.3

**Нэг хүнд ногдох мал аж ахуйн бүтээгдэхүүн.** Нэг хүнд 2012 онд дунджаар 123.5 кг мах, 268.6 л сүү ногдож, өмнөх оныхтой харьцуулахад мах 22.3 кг-аар, сүү 29.5 кг-аар нэмэгдсэн байна. (/хүснэгт-3

#### Нэг хүнд ногдох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн\*

	2010	2011	2012	Улсын дундаж
Мах нядалгааны жингээр, кг	98.0	101.2	123.5	80.7
Сүү, кг	162.2	239.1	268.6	187.0
Өндөг, ширхэг	0.1	1.5	0.1	25

## II.2 2012 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

### II.2.1 Мал бүхий өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлт

**Мал бүхий өрх, малчдын тоо.** 2012 онд 12.2 мянган мал бүхий өрх, үүний дотор 8.1 мянган малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Мөн мал аж ахуйн үйлдвэрлэлд 16.5 мянган малчид ажиллаж байна.

Малчдын 48.5 хувь нь буюу 8.0 мянга нь эмэгтэй малчид байна.

Насны бүлгээр авч үзвэл 42.1 хувь нь 16-34 насны, 48.4 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 9.5 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Хүснэгт 1

#### Өрх, малчдын тоо, насны бүрэлдэхүүн


Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	Зөрүү /+/-
<b>Малтай өрх, (мян.)</b>	14.0	13.6	13.2	12.6	12.2	12.2	-0,49
<b>Малчин өрх, (мян.)</b>	10.1	9.9	9.4	8.9	8.6	8.1	-0.5
<b>Малчдын тоо (мян.)</b>	21.9	20.6	19.6	18.9	17.8	16.5	-1.3
Үүнээс: 16-34 насны	10.9	9.9	9.1	8.3	7.6	7.0	-0.6
35-аас тэтгэвэрт гарах насны	8.3	8.3	8.1	8.4	8.2	8.0	-0.2
Тэтгэврийн	2.7	2.4	2.4	2.2	2.0	1.6	-0.4
<b>Нийт малчдаас эмэгтэй</b>	9.9	9.6	9.2	8.8	8.3	8.0	-0.3
<b>Насны бүтэц %</b>	100.0	100.0	100	100	100	100	
үүнээс: 16-34 насны	49.8	48.1	46.5	43.9	42.4	42.1	-0.3
35-аас тэтгэвэрт гарах насны	37.8	40.3	41.6	44.4	46.1	48.4	2.3
Тэтгэврийн	12.4	11.6	11.9	11.6	11.5	9.5	-2

2012 онд малтай өрхийн тоо 2011 онтой харьцуулахад 49 - өөр, малчин өрхийн тоо 0.6 мянгаар тус тус буурсан байна.

2012 онд 1 малчинд 123 толгой мал ногдож, 2011 онхоос 34 толгойгоор өссөн байна.

Зураг 1

9



**Малчдын нийгэм ахуйн ахуйн зарим үзүүлэлт.** Нийт малчин өрхийн 77.7 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 62.8 хувь нь телевизортой, 24.7 хувь нь авто машинтай, 43.2 хувь нь мотоцикльтой, 1.4 хувь нь трактортой өрх байна. Үүнийг улсын дундажтай харьцуулахад цахилгаан үүсгүүртэй, телевизортой, автомашинтай малчин өрхийн эзлэх хувь 3.5 – 4.3 пунктээр бага, харин мотоцикльтэй өрхийн эзлэх хувь улсын дундажтай ижил түвшинд байна.

Нийт малчин өрхөд цахилгаан үүсгүүртэй өрхийн эзлэх хувь өмнөх оныхоос 8.3, телевизортой өрхийн эзлэх хувь 18.1, мотоцикльтэй өрхийн эзлэх хувь 6.0 пунктээр буурч, автомашинтай өрхийн эзлэх хувь 4.5 хувь, трактортой өрхийн эзлэх хувь 0.2 хувиар тус тус нэмэгдсэн байна. Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 2012 онд 6.3 мянга болж, өмнөх оныхоос 1.1 мянга буюу 8.3 хувь, мотоцикльтой өрхийн тоо 0.7 мянга буюу 6.0 хувиар, телевизортой өрхийн тоо 1.9 мянга буюу 18.1 хувиар буурч, харин автомашинтай өрхийн тоо 0.3 мянга буюу 4.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 2

**Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд**

	Өрхийн тоо, мян.					2012 2011	Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2008	2009	2010	2011	2012		2009	2010	2011	2012	Улсын дундаж
Цахилгаантай	7.6	7.5	7.3	7.4	6.3	85.1	79.8	81.9	86.0	77.7	<b>82.0</b>
Телевизортой	5.9	6.9	7.2	7.0	5.1	72.9	74.4	80.6	80.9	62.8	<b>74.7</b>
Автомашинтай	1.5	1.8	1.8	1.7	2.0	117.6	19.0	20.3	20.2	24.7	<b>28.2</b>
Мотоцикльтэй	3.4	3.6	3.5	4.2	3.5	83.3	38.2	39.3	49.2	43.2	<b>43.2</b>
Трактортой	0.1	0.1	0.1	0.1	0.1	100.0	1.2	1.1	1.2	1.4	

Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 95.2 хувь нь нарны, 0.2 хувь нь салхины, 0.8 хувь нь бага оврын мотор / хонда, ямаха /, 3.8 хувь нь бусад төрлийн цахилгаан эх үүсгүүртэй байна.



### II.2.2 МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

**Малын тоо.** 2012 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2030.7 мянгад хүрч, 2011 оныхоос 198.9 мянгаар буюу 110.9 хувиар өссөн байна.

Төрлөөр авч үзвэл тэмээний тоо 16.9 мянга, адуу 70.4 мянга, үхэр 108 мянга, хонь 976.0 мянга, ямаа 859.3 мянгад хүрч, өмнөх оныхоос тэмээ 1.5 мянга, адуу 6.5 мянга, үхэр 12.3 мянга, хонь 124.5 мянга, ямаа 54.0 мянган толгойгоор таван төрөлдөө өсчээ.

2012 онд 7.2 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 6.7 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо өмнөх оныхоос 38.4 хувиар буюу 2.0 мянган толгойгоор өссөн байна.

Хүснэгт 3

	Малын тоо, төрлөөр					мян.тол	
	2008	2009	2010	2011	2012	2012/2011 %	зөрүү
<b>Бүгд</b>	<b>2499.3</b>	<b>2319.1</b>	<b>1619.3</b>	<b>1831.8</b>	<b>2030.7</b>	<b>110.9</b>	<b>198.9</b>
Тэмээ	16.0	15.9	14.5	15.4	16.9	109.7	1.5
Адуу	79.3	74.8	59.7	63.9	70.4	110.2	6.5
Үхэр	118.2	104.0	84.4	95.7	108.0	112.8	12.3
Хонь	1215.0	1145.1	776.9	851.5	976.0	114.6	124.5
Ямаа	1070.9	979.3	683.8	805.3	859.3	106.7	54.0

Түргэнээс бусад сумдын малын тоо өнгөрсөн оноос 2.2 -21.1 мянган толгойгоор өсч, 9 сум малаа таван төрөл дээрээ өсгөсөн байна.

Сумдыг малын тоогоор бүлэглэвэл:


1. 200.0 мянгаас дээш толгой малтай сумын тоо -1сум

- Тэс / 246.6 мянган толгой /
2. 100.0 – 150.0 мянган толгой малтай сумын тоо – 9 сум  
Улаангом / 137.6 /, Наранбулаг / 146.9 /, Өндөрхангай /132.0, Хяргас /129.2/, Өмнөговь /127.2/, Сагил / 108.7 /, Малчин / 116.4/, Зүүнхангай /106.1/, Цагаанхайрхан / 106.0/,
3. 60.0 -100.0 мянган толгой малтай сумын тоо - 8 сум  
Ховд /97.9/, Бөхмөрөн /90.4/, Тариалан /90.7/, Түргэн /69.9/, Зүүнговь /78.0 /, Завхан /71.7/, Өлгий /71.3/, Давст /63.8/
4. 50.0 мянга хүртэл малтай сумын тоо – 1 сум Баруунтуруун / 40.1 /  
Өнгөрсөн онд 100.0 - 150.0 мянган толгой малтай 7 сум байсан бол одоо 9 болж өсчээ.  
Аймгийн нийт малын 12.1 хувийг эзэлж буй Тэс сум 246.6 мянган толгой малтайгаар хамгийн олон малтай, 2.0 хувийг эзэлдэг Баруунтуруун сум 40.1 мянган малтай болж хамгийн цөөн малтайд орж байна.  
Мал тооллогын 2012 оны дүнгээр аймгийн хэмжээнд нийт малын тоогоор Тэс сум, Тэмээгээр Завхан сум, мөн адуу, үхэр, хониор Тэс сум, ямаагаар Наранбулаг сум тус тус тэргүүлж байна.

Нийт малын тоогоор эхний 5-д орох сумууд	Үүнээс	
	Тэмээгээр /мян.тол/	адугаар /мян.тол/
Тэс -246.6 мян.тол	Завхан- 5.6	Тэс - 9.2
Наранбулаг-146.9 мян.тол	Тэс - 2.2	Өндөрхангай -6.6
Улаангом- 137.7 мян.тол	Наранбулаг - 2.0	Зүүнхангай - 5.9
Өндөрхангай -132.0 мян.тол	Өлгий - 1.3	Улаангом - 6.4
Хяргас-129.2 мян.тол	Өмнөговь - 1.0	Зүүнговь - 4.5
Дүнд эзлэх хувь- 39.0	Дүнд эзлэх хувь- 71.4	Дүнд эзлэх хувь- 46.3
Өсгөсөн сум- 18	Өсгөсөн сум- 10	Өсгөсөн сум- 19
Өсөлт бууралтын хувь- 110.8	Өсөлт бууралтын хувь- 109.6	Өсөлт бууралтын хувь- 110.1

Үхрээр /мян.тол//	хониор /мян.тол//	Ямаагаар /мян.тол/
Тэс - 23.3	Тэс - 149.8	Наранбулаг - 46.8
Улаангом - 17.1	Наранбулаг - 72.7	Тэс - 55.2
Зүүнговь - 6.9	Хяргас - 71.3	Өмнөговь - 62.4
Өндөрхангай - 6.8	Малчин - 68.4	Ховд - 49.8
Сагил - 5.9	Улаангом - 64.6	Цагаанхайрхан - 54.4
Дүнд эзлэх хувь- 55.5	Дүнд эзлэх хувь- 43.7	Дүнд эзлэх хувь- 35.5
Өсгөсөн сум- 19	Өсгөсөн сум- 19	Өсгөсөн сум- 15
Өсөлт бууралтын хувь- 112.9	Өсөлт бууралтын хувь- 116.4	Өсөлт бууралтын хувь- 106.7

Аймгийн нэг хүнд дунджаар 27 толгой мал ноогдож сумдаар авч үзвэл Улаангом сумын нэг хүнд дунджаар 5, Баруунтуруун суманд 16, Тариалан суманд 24 толгой мал ноогдож байгаа нь аймгийн дунджаас 3 – 22 толгой малаар доогуур, харин бусад сумдад 29 – 54 толгой мал ноогдож байгаа нь аймгийн дунджаас 2 – 27 толгой малаар илүү байна.




Нийт малын 29.8 хувь буюу 605.7 мянган мал, зүүн бүсэд 28.1 хувь буюу 570.2 мянган мал, өмнөд бүсэд 18.9 хувь буюу 384.3 мянган мал, хойт бүсэд 16.4 хувь буюу 332.8 мянган мал, төвийн бүсэд 6.8 хувь буюу 137.7 мянган мал тус тус ноогдож байна.

Бүс нутгаар авч үзвэл Баруун бүсийн мал 2011 оныхоос 79.2 мянган толгой буюу 15.0 хувь, Өмнөд бүсийн мал 44.3 мянган толгой буюу 13.0 хувь, Хойд бүсийн мал 11.1 мянган толгой буюу 3.4 хувь, Улаангом сумын мал 10.0 мянган толгой буюу 7.8 хувь, Зүүн бүсийн малын тоо 54.9 мянган толгой буюу 10.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 4

#### Малын тоо, бүс нутгаар

Бүс	2008	2009	2010	2011	2012	МЯН.ТОЛ	
						2012/2011	
						%	Зөрүү
Баруун	742.3	662.1	434.7	526.5	605.7	115.0	79.2
Хойд	433.0	404.2	305.4	321.7	332.8	103.5	11.1
Зүүн	630.5	622.7	461.6	515.3	570.2	110.7	54.9
Өмнөд	508.2	457.9	300.2	340.0	384.3	113.0	44.3
Төв	185.4	172.2	117.4	128.3	137.7	107.3	9.4



Таван төрлийн малын өсөлт бууралтыг 2011 онтой харьцуулан сумдаар авч үзэхэд тэмээ 10 сум, адуу 19 сум, үхэр 19 сум, хонь 17 сум, ямаа 14 суманд тус тус өсчээ. Нийт мал сүргийн 90.4 хувийг бог мал, 9.6 хувийг бод мал эзэлж байна.

хонь 48.1, ямаа 42.3, үхэр 5.3, адуу 3.5, тэмээ 0.8 хувийг тус тус эзэлж, өнгөрсөн оноос нийт хонины эзлэх хувь 1.6, үхэр 0.1 пунктээр өсч, адуу, тэмээний эзлэх хувь өнгөрсөн оны түвшинд, харин ямааны эзлэх хувь 1.7 пунктээр буурчээ.

**Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь**


	2008	2009	2010	2011	2012	Улсын дундаж, 2012 он
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	<b>100.0</b>
Тэмээ	0.6	0.7	0.9	0.8	0.8	<b>0.7</b>
Адуу	3.2	3.2	3.7	3.5	3.5	<b>5.7</b>
Үхэр	4.7	4.5	5.2	5.2	5.3	<b>6.3</b>
Хонь	48.6	49.4	48.0	46.5	48.1	<b>44.3</b>
Ямаа	42.8	42.2	42.2	44.0	42.3	<b>42.9</b>

Ялангуяа эртнээс ардын дунд уламжлагдан ирсэн бог малын дотор хонь 75 хувь, ямаа 25 хувь байх харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр алдагдсаар байна. 2012 оны байдлаар авч үзэхэд бог малын 46.8 хувийг ямаа эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос эзлэх хувийн жин нь 1.8 пунктээр буурсан байна.

Давст, Цагаанхайрхан, Баруунтуруун, Бөхмөрөн, Өлгий, Завхан, Ховд сумдын бог малынх нь 51.4 – 71.0 хувийг ямаан сүрэг эзэлж байгаа нь аймгийн дунджаас ихээхэн өндөр байна. Ер нь Тэс,

Зүүнговь сумдаас бусад сумдын бог малын дотор ямааны сүргийн эзлэх тэнцвэрт харьцаа алдагдсан хэвээр байна.

Зураг 4



2012 оны байдлаар ямаан сүргийн эзлэх хувь буурсан ч мал сүргийн бүтцийн зохисгүй өөрчлөлт хадгалагдсаар байгаа нь анхаарал татсан асуудал юм. Цаашид ямаан сүргийн тоо толгойн өсөлт үргэлжлэвэл байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд ямар нөлөөтэйг тогтоож, сүргийн бүтцийн зохистой харьцааг тодорхойлж, энэ талаар мэргэжлийн байгууллагаас асуудал боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Зураг 5



**Хувийн /амины/ малын тоо.** 2012 оны мал тооллогын дүнгээр Нийт мал сүргийн 99.4 /2018.6 мянга / хувь нь амины аж ахуйд, 0.6 хувь нь /12.1 мянган/ албан газарт ноогдож , амины малын тоо өнгөрсөн оноос 199.0 мянган толгойгоор өссөн байна.

Тэмээний 99.9 хувь, адууны 97.9, үхрийн 99.9, хонины 99.2, ямааны 99.7 хувь нь хувийн аж ахуйд байна . Хувийн малын тоо өмнөх оныхоос 199.0 мянгаар буюу 10.9 хувиар өслөө.

Хүснэгт 6

**Хувийн малтай өрх, тэдгээрийн малын тоо**

МЯН.ТОЛ

	Малтай өрхийн тоо, мян.өрх	Бүгд	үүнээс				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1993	18.9	1509.7	25.6	102.0	143.3	896.7	342.1
1994	19.1	1601.8	25.0	110.5	161.7	899.4	405.2
1995	18.7	1657.0	24.5	117.3	178.7	865.5	471.0
1996	18.1	1679.5	24.0	120.2	182.1	850.6	502.6
1997	17.8	1780.7	23.8	121.9	180.8	894.0	560.2
1998	17.4	1880.7	24.3	124.4	182.8	934.8	614.4
1999	16.6	1847.4	22.6	114.3	167.1	938.8	604.6
2000	15.7	1550.7	18.2	74.0	105.5	834.6	518.4
2001	15.0	1549.4	16.7	65.5	90.3	810.0	566.9
2002	14.2	1450.8	14.8	59.4	83.1	740.0	553.5
2003	14.0	1645.5	15.5	62.4	89.2	785.1	693.3
2004	14.1	1930.1	15.8	68.6	100.2	914.0	831.5
2005	14.0	2003.8	15.7	72.0	108.7	975.6	831.8
2006	14.0	2381.8	16.1	78.9	119.8	1152.0	1015.0
2007	14.0	2635.8	16.5	83.8	130.0	1266.0	1139.4
2008	13.6	2482.6	16.0	78.2	117.9	1203.5	1066.9
2009	13.2	2302.7	15.9	73.8	103.8	1133.7	975.6
2010	12.6	1608.5	14.5	58.8	84.2	769.4	681.6
2011	12.2	1819.6	15.4	62.6	95.5	843.2	802.9
2012	12.2	2018.6	16.9	68.9	107.9	967.8	857.1

2012 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 0.8 хувийг тэмээ, 3.4 хувийг адуу, 5.3 хувийг үхэр, 47.9 хувийг ямаа, 42.5 хувийг хонь эзэлж байна.

Мал бүхий 12.2 мянган өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл 7.2 хувь буюу 0.9 мянга нь 10 хүртэл малтай, 12.2 хувь буюу 1.5 мянга нь 11-30 малтай, 9.3 хувь буюу 1.1 мянга нь 31-50 малтай, 16.3 хувь буюу 2.0 мянга нь 51-100 малтай, 26.4 хувь буюу 3.2 мянга нь 101-200 малтай, 23.1 хувь буюу 2.8 мянга нь 201-500 малтай, 5.4 хувь буюу 0.7 мянга нь 500-аас дээш малтай өрх байна.

100 хүртэлх малтай өрх нийт малтай өрхийн 45.2 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 3.2 пунктээр, 101 – 200 толгой малтай өрхийн эзлэх хувь өнгөрсөн оноос 0.3 пунктээр багасч, 201 – 500 толгой малтай өрхийнх 2.2 пунктээр, 501 – 999 малтай өрхийнх 1.2 пунктээр тус тус өсчээ. 1000-аас дээш малтай 102 өрх байгаа нь 2011 оныхоос 21 өрхөөр өссөн байна.

Бүлэглэлтээс харахад малтай өрхийн дийлэнхи хувийг эзэлдэг 200 хүртэл малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 2011 онд 75.1 хувьтай байсан бол 2012 онд 71.6 хувь болж, өмнөх оныхоос 3.5 пунктээр буурчээ.

Аймгийн нийт өрх 19.8 мянга, үүний 61.6 хувь буюу 12.2 мянган өрх нь малтай өрх байх ба эдгээр мал бүхий өрхийн 71.6 хувь нь буюу 8.7 мянган өрх 200 хүртэл малтай өрх байна.


## Малтай өрхийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Улсын дундаж хувь	
	2011	2012	2011	2012	2011	2012
<b>Дүн</b>	<b>12235</b>	<b>12186</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
100 хүртэл	5925	5502	48.4	45.2	48.4	43.8
101-200	3261	3216	26.7	26.4	23.3	23.3
201-500	2562	2813	20.9	23.1	21.6	24.3
501-999	406	553	3.3	4.5	5.3	6.9
1000-1499	75	95	0.6	0.8	1.1	1.5
1500-2000	3	5	0.02	0.04	0.1	0.2
2001-ээс дээш	3	2	0.02	0.02	0.1	0.1

Түргэн, Өмнөговь, Өлгий, Тариалан, Зүүнговь, Улаангом, Баруунтуруун, Өндөрхангай сумдын 100 хүртэл толгой малтай өрх 45.4 – 74.3 хувь байгаа нь аймгийн дунджаас 0.2 – 29.1 пунктээр илүү байна.

Бүсээр авч үзвэл, 2012 онд 200 хүртэл толгой малтай өрхийн нийт мал бүхий өрхөд эзлэх хувь Баруун бүсэд 80.4 хувь, Хойд бүсэд 74.5 хувь, Өмнөд бүсэд 70.0 хувь, Зүүн бүсэд 73.6 хувь, Улаангомд 71.3 хувь байсан бол 2012 онд Баруун бүсийнх 75.8 хувь, Хойд бүсийнх 71.3 хувь, Өмнөд бүсийнх 65.8 хувь, Зүүн бүсийнх 70.9 хувь, Улаангомных 86.4 хувь болсон байна. Эндээс харахад бүх бүсэд 200 хүртэл толгой буюу цөөн малтай өрхийн хувийн жин буурчээ.

Зураг 6



Нийт малтай өрхөд 200 хүртэл малтай өрхийн эзлэх хувь улсын дунджаас 4.5 пункт , 201- 999 хүртэл малтай өрхийн эзлэх хувь 4.0 пункт, 1000-аас дээш малтай өрхийн эзлэх хувь 0.9 пунктээр тус тус бага байна.

200 хүртэл малтай өрхийн эзлэх хувь өмнөх оныхоос Түргэн суманд 0.7 пунктээр өсч, бусад сумдад 0.3 – 8.8 пунктээр буурчээ.

Хүснэгт 8

**Иргэдийн малын бүлэглэлт , сумаар**

	Малтай өрхийн тоо	100 хүртэлх малтай өрхийн эзлэх хувь		101-200 хүртэлх малтай өрхийн эзлэх хувь		201-500 хүртэлх малтай өрхийн эзлэх хувь		501-1000 хүртэлх малтай өрхийн эзлэх хувь		1000-с дээш хүртэлх малтай өрхийн эзлэх хувь	
		2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012
1.Баруунтуруун	470	78.3	74.3	14.2	15.7	5.8	8.1	1.1	1.3	0.6	0.6
2.Бөхмөрөн	482	37.9	36.1	32.1	33.6	24.2	22.8	5.2	6.4	0.6	1.0
3.Давст	298	45.3	41.9	22.8	23.2	22.8	23.8	7.1	9.4	1.9	1.7
4.Завхан	445	43.4	38.9	34.2	31.7	20.1	25.6	2.3	3.4	0.0	0.4
5.Зүүнговь	534	58.3	50.0	22.5	25.3	17.3	21.5	1.5	2.6	0.4	0.6
6.Зүүнхангай	577	42.1	36.9	32.9	29.3	21.3	28.2	3.4	4.9	0.4	0.7
7.Малчин	576	37.8	33.7	24.4	25.9	34.1	33.7	3.3	6.1	0.4	0.7
8.Наранбулаг	898	47.1	42.9	30.9	29.2	18.6	22.7	3.2	4.7	0.2	0.6
9.Өлгий	487	58.9	54.2	24.1	25.5	13.4	13.6	2.6	5.5	1.0	1.2
10.Өмнөговь	934	58.2	52.6	24.9	25.7	15.0	18.7	1.6	2.8	0.3	0.2
11. Өндөрхангай	766	44.9	45.4	26.6	24.7	24.3	24.7	3.1	3.9	1.0	1.3
12.Сагил	440	31.2	30.7	30.3	25.2	26.4	30.7	10.5	10.9	1.5	2.5
13.Тариалан	742	61.8	55.5	22.7	25.6	14.6	17.4	0.9	1.5	0.0	0.0
14. Түргэн	417	48.5	49.2	21.1	21.1	23.9	23.5	6.5	6.2	0.0	0.0
15.Тэс	1216	31.1	30.9	29.3	28.1	34.9	35.3	3.7	4.7	1.0	1.0
16.Ховд	587	41.9	40.2	34.2	32.5	20.4	22.7	2.5	3.6	1.0	1.0
17.Хяргас	512	33.7	29.7	25.4	24.8	32.8	33.2	6.0	9.6	2.1	2.7
18. Цагаанхайрха	485	44.7	39.2	24.3	26.0	22.9	24.3	6.8	8.7	1.4	1.9
19.Улаангом	1320	64.0	61.6	25.1	24.8	10.0	12.3	0.7	1.3	0.1	0.1
<b>Дүн</b>	<b>12186</b>	<b>48.4</b>	<b>45.2</b>	<b>26.7</b>	<b>26.4</b>	<b>20.9</b>	<b>23.1</b>	<b>3.3</b>	<b>4.5</b>	<b>0.7</b>	<b>0.8</b>
Баруун бүс	4093	51.9	47.4	28.5	28.4	17.0	20.1	2.2	3.6	0.4	0.6
Хойд бүс	1637	40.7	46.8	24.1	24.5	21.1	22.5	3.6	5.1	0.8	1.0
Өмнөд бүс	2298	52.5	39.3	28.1	26.5	24.1	27.0	4.9	6.0	0.9	1.3
Зүүн бүс	2838	40.2	44.5	27.2	26.4	21.6	23.6	3.5	4.5	0.7	0.9
Төвийн бүс	1320	64.0	42.2	26.2	25.4	22.9	25.1	5.1	6.2	0.8	1.1
	<b>12186</b>	<b>48.4</b>	<b>45.2</b>	<b>26.7</b>	<b>26.4</b>	<b>20.9</b>	<b>23.1</b>	<b>3.3</b>	<b>4.5</b>	<b>0.7</b>	<b>0.8</b>

201 – 999 хүртэл малтай өрхийн эзлэх хувь 2011 оныхоос Түргэн, Бөхмөрөн сумдад 0.1 – 0.7 пунктээр буурч, бусад сумдад 1.2 – 8.4 пунктээр тус тус өсчээ. 1000-аас дээш малтай өрхийн эзлэх хувь Давст, Өмнөговь сумдад 0.1 – 0.2 пунктээр буурч, бусад сумдад 0.2 – 1.0 пунктээр өсчээ.

## Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр

	Улсын дундаж	2012	Үүнээс				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
<b>Дүн</b>	<b>195</b>	<b>167</b>	<b>1</b>	<b>6</b>	<b>9</b>	<b>79</b>	<b>70</b>
10 хүртэл	6	7	0	0	3	1	1
11-30	20	20	0	1	3	5	11
31-50	40	40	0	2	4	12	23
51-100	74	74	1	3	6	26	38
101-200	145	144	1	5	9	58	70
201-500	311	304	3	10	14	153	123
501-999	663	636	4	18	22	364	228
1000-1499	1149	1107	10	30	33	674	360
1500-2000	1683	1625	7	99	59	1034	426
2001-ээс дээш	2575	4052	18	169	36	1931	1900

Манай аймагт дунджаар малтай нэг өрхөд 167 толгой мал ногдож байгаа нь 2012 оныхоос 18 малаар их, харин улсын дунджаас 28 малаар бага байна. Малтай 1 өрхөд дунджаар тэмээ 1, адуу 6, үхэр 9, хонь 79, ямаа 70 ногдож байна. 1 өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 89.2 хувь нь бог мал, 10.8 хувь нь бод мал байна.

## Иргэдийн малын бүлэглэлт, сумаар

	Малтай өрхийн тоо	200 хүртэл малтай өрхийн эзлэх хувь		201-999 малтай өрхийн эзлэх хувь		1000-с дээш малтай өрхийн эзлэх хувь	
		өрх	хувь	өрх	хувь	өрх	хувь
Баруунтуруун	470	423	90.0	44	9.4	3	0.6
Бөхмөрөн	482	336	69.7	141	29.3	5	1.0
Давст	298	194	65.1	99	33.2	5	1.7
Завхан	445	314	70.6	129	29.0	2	0.4
Зүүнговь	534	402	75.3	129	24.2	3	0.6
Зүүнхангай	577	382	66.2	191	33.1	4	0.7
Малчин	576	343	59.5	229	39.8	4	0.7
Наранбулаг	898	647	72.0	246	27.4	5	0.6
Өлгий	487	388	79.7	93	19.1	6	1.2
Өмнөговь	934	731	78.3	201	21.5	2	0.2
Өндөрхангай	766	537	70.1	219	28.6	10	1.3
Сагил	440	246	55.9	183	41.6	11	2.5
Тариалан	742	602	81.1	140	18.9	0	0.0
Түргэн	417	293	70.3	124	29.7	0	0.0
Тэс	1216	718	59.0	486	40.0	12	1.0
Ховд	587	427	72.7	154	26.2	6	1.0
Хяргас	512	279	54.5	219	42.8	14	2.7
Цагаанхайрхан	485	316	65.2	160	33.0	9	1.9
Улаангом	1320	1140	86.4	179	13.6	1	0.1
<b>Нийт</b>	<b>12186</b>	<b>8718</b>	<b>71.5</b>	<b>3366</b>	<b>27.6</b>	<b>102</b>	<b>0.8</b>
Баруун бүс	4093	518.2	75.7	160.5	23.7	3.5	0.6
Хойд бүс	1637	267.3	71.3	164.2	27.6	5.8	1.0
Өмнөд бүс	2298	414.5	65.8	240.0	33.0	8.0	1.3
Зүүн бүс	2838	435.5	71.0	184.0	28.1	5.3	0.9
Төвийн бүс	1320	1140.0	67.6	713.0	31.3	22.0	1.1
	<b>12186</b>	<b>8718.0</b>	<b>71.5</b>	<b>3366.0</b>	<b>27.6</b>	<b>102.0</b>	<b>0.8</b>

Гэхдээ өнгөрсөн онд манай аймгийн ихэнх нутагт зуншлага болон өвөлжилт сайхан байснаас шалтгаалан цөөн малтай өрхийн тоо ихэнх суманд буурав. Бүлэглэлтээс харахад малтай өрхийн дийлэнх хувийг эзэлдэг 200 хүртэл малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 2011 онд 75.1 байсан бол 2012 онд 71.5 хувь болж өмнөх оныхоос 3.6 пунктээр буурсан байна.

## Малчин өрхийн малын бүлэглэлт, сумаар

	Малчин өрхийн тоо		Малчин өрхийн малын тоо		Үүнээс				
	2011	2012	2011	2012	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1.Баруунтуруун	236	215	6514	30936	64	2841	3027	11348	13656
2.Бөхмөрөн	301	305	70498	78102	99	2235	3202	33564	39002
3.Давст	195	176	54105	55000	176	930	3107	25603	25184
4.Завхан	333	338	53765	62011	5116	2944	465	17453	36033
5.Зүүнговь	433	429	60238	73577	609	4268	6063	39055	23582
6.Зүүнхангай	445	385	85378	87824	48	4943	3770	45753	33310
7.Малчин	446	442	93757	104133	438	2594	3884	62364	34853
8.Наранбулаг	729	707	119516	136164	1947	3184	3496	68782	58755
9.Өлгий	294	287	51532	61246	1240	1315	1068	22152	35471
10.Өмнөговь	597	568	90836	104733	993	2442	2881	48649	49768
11.Өндөрхангай	557	521	107381	111667	326	5731	5347	53034	47229
12.Сагил	349	338	96643	99701	171	2486	5320	49564	42160
13.Тариалан	529	468	69693	78153	597	1175	1979	43470	30932
14.Түргэн	259	206	56757	56264	265	1375	1964	31771	20889
15.Тэс	1085	1014	221271	227591	2138	8618	21055	139168	56612
16.Ховд	426	403	80179	83609	897	2965	3384	24928	51435
17.Хяргас	407	356	103509	111853	348	2990	3360	62736	42419
18.Цагаанхайрхан	282	258	81204	86654	241	2920	1608	38111	43774
19.Улаангом	727	656	93344	99256	405	4649	12329	46609	35264
<b>Дүн</b>	<b>8630</b>	<b>8072</b>	<b>1596120</b>	<b>1748474</b>	<b>16118</b>	<b>60605</b>	<b>87309</b>	<b>864114</b>	<b>720328</b>
Баруун бүс	2908	462	77587	87653	1798	2338	2212	37572	43732
Хойд бүс	1104	256	78376	86557	630	3020	3447	42900	36560
Өмнөд бүс	1520	345	113786	119695	653	4523	6664	62380	45476
Зүүн бүс	2371	560	90166	96087	472	3267	5374	46662	40312
Төвийн бүс	727	656	340373	371768	3241	11969	17238	186740	152581
	<b>8630</b>	<b>8072</b>	<b>1596120</b>	<b>1748474</b>	<b>16118</b>	<b>60605</b>	<b>87309</b>	<b>864114</b>	<b>720328</b>

2012 оны байдлаар амьжиргааны эх үүсвэр нь болсон малчин өрхийн эзэмшилд нийт малын 86.1 хувь буюу 1748.5 мянган толгой мал байна. 2011 оны байдлаар малчин өрхөд дунджаар 185 толгой мал ногдож байсан бол 2012 онд 217 толгой мал ногдож, үүний дотор тэмээ 2, адуу 8, үхэр 11, хонь 107, ямаа 89 ноогдож байна.

**Хээлтэгч мал.** 2012 оны эцэст 897.4 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оныхоос 101.5 мянга буюу 12.8 хувиар буурсан байна. Төрлөөр авч үзвэл ингэ 0.4 мянга, гүү 1.3 мянга, үнээ 3.2, эм хонь 59.7 мянга, ямаа 36.9 мянган толгойгоор тус тус өссөн байна.

Хүснэгт 12


**Хээлтэгч малын тоо**

мян.тол

	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
						%	Зөрүү
<b>Бүгд</b>	<b>1136.1</b>	<b>1077.7</b>	<b>803.4</b>	<b>795.9</b>	<b>897.4</b>	<b>112.8</b>	<b>101.5</b>
Тэмээ	5.0	5.1	4.9	5.2	5.6	107.7	0.4
Адуу	22.7	22.1	18.5	18.8	20.1	106.9	1.3
Үхэр	50.6	47.3	40.1	42.7	45.9	107.5	3.2
Хонь	570.2	549.2	397.9	389.4	449.1	115.3	59.7
Ямаа	487.5	454.0	341.9	339.8	376.7	110.9	36.9

Хээлтэгч мал нийт малын 44.2 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 33.0 хувь, адуун сүргийн 28.6 хувь, үхэр сүргийн 42.5 хувь, хонин сүргийн 46.0 хувь, ямаан сүргийн 43.8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 7



Хээлтэгч малын тоо өнгөрсөн оныхоос Түргэн суманд 7-оор, бусад бүх сумдад 0.4 – 11.3 мянган толгойгоор тус тус өсчээ.

Баруун бүсийн нийт малын 42.8 хувь, Хойд бүсийн нийт малын 45.2 хувь, Төвийн бүсийн нийт малын 47.0 хувь, Зүүн бүсийн нийт малын 44.4 хувь, Өмнөд бүсийн нийт малын 44.1 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

Хүснэгт 13

**Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь**

	2008	2009	2010	2011	2012
Бүгд	45.5	46.5	49.6	43.9	44.2
Ингэ	30.9	31.8	33.8	33.8	34.3
Гүү	28.7	29.6	31.0	29.3	28.6
Үнээ	42.9	45.5	47.5	44.6	42.5
Эм хонь	46.9	47.9	51.2	45.7	46.0
Эм ямаа	45.5	46.4	50.0	42.2	43.8

Мал аж ахуйн эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50.0 - 55.0 хувь, бог малын хувьд сүргийн 60.0 - 65.0 хувийг эзэлж байвал зохистой байна гэж үздэг бөгөөд энэ харьцаа сүүлийн жилүүдэд алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 35.7 хувь, бог малд дунджаар 45.9 хувь байна.

**Төл бойжилт.** Оны эхний эхийн 89.2 хувь буюу 710.2 мянган эх мал төллөж, гарсан төлийн 92.0 хувь буюу 657.1 мянган төл бойжиж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад төллөлтийн хувь 10.7 пунктээр буурч, бойжилтын хувь 1 пунктээр, төлийн хорогдол 11.7 хувиар буюу 7.7 мянгаар буурсан байна. Бөхмөрөн, Тэс, Өндөрхангай, Түргэн, Зүүнхангай сумдын төл бойжилт 73.3 – 89.5 хувь байгаа нь аймгийн дунджаас 2.5 – 18.7 пунктээр бага, бусад сумдын төл бойжилт 90.8 -98.2 хувь байгаа нь аймгийн дунджаас 1.8 – 6.2 пунктээр илүү байна.


## Төл бойжилт

мян.тол

	Бүгд			үүнээс				
	2010	2011	2012	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Гарсан төл	739.3	724.3	714.3	2.7	14.5	33.5	363.3	300.3
Бойжсон төл	336.2	659.4	657.1	2.5	12.8	31.6	337.5	272.7
Бойжилтын хувь	45.5	91.0	92.0	92.4	88.1	94.5	92.9	90.8
Бойжилтын хувь, улсын дундаж	68.0	94.9	96.5	97.6	95.4	96.9	97.0	96.1

Төл бойжилтын хувь 2012 онд 92.0 байгаа нь улсын дунджаас 4.5 пунктээр доогуур байна.

Зураг 8



Бүсээр авч үзвэл баруун, өмнөд, төвийн бүсэд бойжуулсан төлийн тоо 1.1 – 5.0 мянгаар өсч, хойд, зүүн бүсэд бойжуулсан төлийн тоо 2.0 – 11.2 мянгаар буурчээ. Нийт бойжуулсан төлийн 27.9 хувь нь Баруун бүсэд, 28.6 хувь нь Зүүн бүсэд, 18.4 хувь нь Өмнөд бүсэд, 17.2 хувь нь Хойд бүсэд, 7.9 хувь нь Төвийн бүсэд ногдож байна.


Хүснэгт 15

**Бойжуулсан төл /толгой/**

Он	Бойжуулсан төл	Үүнээс				
		ботго	унага	тугал	хурга	ишиг
2003	551286	1466	8754	24885	297246	218935
2004	663817	1930	12717	31418	348980	268762
2005	580155	1655	11553	31897	328321	206729
2006	796386	1842	13267	31619	418408	331250
2007	833580	1785	12005	34702	448036	337052
2008	679994	1760	9788	29497	386389	252560
2009	663846	2056	11374	27755	364574	258087
2010	336193	1423	6746	21209	194502	112313
2011	659423	1984	11717	27186	331098	287438
2012	657061	2451	12805	31647	337505	272653

100 эх малаас 83 төл үүний дотор 47 ботго, 68 унага, 74 тугал, 87 хурга, 80 ишиг бойжуулсан нь өнгөрсөн оныхоос ботго 6, унага 5, тугал 6, хурга 4, ишиг 17 төлөөр өссөн байна. 100 эхээс 83 төл бойжуулсан нь өнгөрсөн оноос 1 төлөөр өсч, улсын дунджаас 2 төлөөр бага байна. / Улсын дундаж 100 эхийн төл 85 /

Зураг 9



Хүснэгт 16

Он	Бойжуулсан төл	Үүнээс				
		ботго	унага	тугал	хурга	ишиг
1999	70	28	41	58	75	68
2000	53	18	20	35	62	46
2001	69	27	35	51	74	70
2002	62	23	40	59	68	55
2003	82	35	50	65	84	84
2004	91	44	71	78	95	90
2005	70	38	62	75	79	60
2006	88	42	69	71	91	87
2007	82	40	57	71	86	80
2008	59	37	43	55	67	52
2009	58	41	50	55	64	53
2010	31	28	31	45	35	25
2011	82	41	63	68	83	63
<b>Улсын дундаж, 2012</b>	85	55	74	78	89	84
2012	83	47	68	74	87	80

**Том малын зүй бус хорогдол.** 2012 онд оны эхний малын 2.7 хувь буюу 49.0 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оныхоос 0.2 хувь буюу 8.3 мянган толгойгоор өссөн байна.

Нийт хорогдлын 49.0 хувийг хонь, 42.6 хувийг ямаа, 5.0 хувийг үхэр, 3.1 хувийг адуу, 0.3 хувийг тэмээний хорогдол тус тус эзэлж байна.

Хүснэгт 17

**Том малын зүй бус хорогдол**

мян.тол

	2008	2009	2010	2011	2012
<b>Бүгд</b>	<b>223.7</b>	<b>286.0</b>	<b>666.2</b>	<b>40.6</b>	<b>49.0</b>
Тэмээ	0.5	0.6	1.5	0.1	0.1
Адуу	5.1	6.4	15.9	1.9	1.5
Үхэр	14.4	17.8	28.0	2.4	2.5
Хонь	105.3	136.4	345.0	19.6	24.0
Ямаа	98.4	124.8	275.8	16.6	20.9

Нийт хорогдсон малын 88.2 хувь буюу 43.2 мянга нь гэнэтийн аюулаар, 11.8 хувь буюу 5.8 мянга нь өвчнөөр болон бусад шалтгаанаар хорогджээ.

Өндөрхангай, Түргэн, Тэс, Баруунтуруун, Бөхмөрөн, Зүүнхангай сумдын оны эхний малын 3.7 – 7.6 хувь нь хорогдож аймгийн дунджаас 1.0 – 4.9 пунктээр илүү, бусад сумдын оны эхний малын 0.3 -2.4 пунктээр бага байна.

Зураг 10



Нийт хорогдлын 13.1 хувь баруун бүс, 30.4 хувийг зүүн бүс, 21.0 хувийг хойд бүс, 30.2 хувийг өмнөд бүс, 5.3 хувийг төвийн бүс эзэлж байна.

Бүсүүдэд хорогдлын хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад баруун, зүүн, төвийн бүсүүдэд 0.4 – 7.0 мянган толгойгоор өсч, хойд, өмнөд бүсүүдэд 0.3 – 0.9 мянган толгойгоор буурсан байна.

Хүснэгт 18

**Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь**

	2008	2009	2010	2011	2012	Улсын дундаж
<b>Бүгд</b>	<b>8.4</b>	<b>11.5</b>	<b>28.7</b>	<b>2.5</b>	<b>2.7</b>	<b>1.2</b>
Тэмээ	2.8	3.8	9.4	0.7	0.8	1.0
Адуу	6.0	8.1	21.3	3.2	2.4	1.6
Үхэр	11.1	15.1	26.9	2.8	2.6	0.5
Хонь	8.2	11.3	30.1	2.5	2.8	1.1
Ямаа	8.6	11.7	28.2	2.4	2.6	1.2

2011 онд 35.7 мянган мал гэнэтийн аюулаар хорогдсон нь өмнөх оныхоос 527.3 мянган толгойгоор буюу 15.8 дахин буурчээ. Гэнэтийн аюулаар хорогдсон малын 89.4 хувийг бог мал, 10.6 хувийг бод мал эзэлж байна.

Хүснэгт 19

**Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо**

МЯН.ТОЛ

	2008	2009	2010	2011	2012
<b>Бүгд</b>	<b>128.9</b>	<b>162.1</b>	<b>563.0</b>	<b>35.7</b>	<b>15.4</b>
Тэмээ	0.2	0.3	1.3	0.1	0.05
Адуу	2.6	3.2	13.1	1.6	0.7
Үхэр	9.2	9.6	23.4	2.0	0.8
Хонь	61.8	76.5	297.3	17.2	6.8
Ямаа	55.2	72.4	227.9	14.7	7.1

**Малын хээл хаялт, сувайралт.** 2012 онд оны эхний хээлтэгч малын 9.7 хувь нь буюу 87.4 мянган мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо өмнөх оныхоос 23.3 хувь буюу 16.5 мянгаар өссөн байна.

Төл өгөөгүй хээлтэгч малын 55.8 хувь буюу 48.8 мянга нь сувайрсан хээлтэгч, 44.2 хувь буюу 38.6 мянга нь хээл хаясан хээлтэгч байгаа бөгөөд төл өгөөгүй хээлтэгч малын 84.0 хувийг бог мал, 16.0 хувийг бод мал эзэлж байна. Хүснэгт 20

**Хээл хаяж, сувайрсан эх малын тоо**  
МЯН.ТОЛ

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
<b>Бүгд</b>	<b>166.6</b>	<b>70.9</b>	<b>87.4</b>	<b>56.6</b>	<b>49.7</b>	<b>48.8</b>	<b>110.0</b>	<b>21.2</b>	<b>38.6</b>
Ингэ	0.3	0.28	0.2	0.3	0.2	0.2	0.01	0.0	0.0
Гүү	7.2	4.5	4.7	5.0	4.1	4.2	2.2	0.4	0.5
Үнээ	11.2	9.4	9.1	9.6	8.7	8.3	1.6	0.7	0.8
Эм хонь	45.0	26.3	26.3	26.5	21.4	19.9	18.5	4.9	6.4
Эм ямаа	102.8	30.5	47.1	15.1	15.3	16.2	87.7	15.2	30.9

Хүснэгт 21


**Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь**

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
<b>Бүгд</b>	<b>15.4</b>	<b>8.8</b>	<b>9.7</b>	<b>5.2</b>	<b>6.2</b>	<b>5.4</b>	<b>10.2</b>	<b>2.6</b>	<b>4.3</b>
Ингэ	5.3	4.4	2.5	5.1	4.2	2.4	0.2	0.2	0.1
Гүү	32.5	24.1	23.5	22.6	22.0	20.8	9.9	2.1	2.7
Үнээ	23.7	23.3	19.9	20.3	21.7	18.1	3.4	1.6	1.8

Эм хонь	8.2	6.6	5.8	4.8	5.4	4.4	3.4	1.2	1.4
Эм ямаа	22.6	9.0	12.5	3.3	4.5	4.3	19.3	4.5	8.2
Улсын дундаж	<b>23.3</b>	<b>12.3</b>	<b>11.3</b>	<b>13.3</b>	<b>9.4</b>	<b>8.3</b>	<b>10.0</b>	<b>2.9</b>	<b>3.0</b>

Хээл хаяж, сувайрсан эх малын 18.5 хувь нь Өмнөд, 31.6 хувь нь Баруун, 24.6 хувь нь Зүүн, 17.4 хувь нь Хойд бүсэд, 7.9 хувь нь Улаангом хотод ногдож байна.

Зураг 11



**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.

Хүснэгт 22

**Хээлтүүлэгч малын тоо**

МЯН.ТОЛ

	Бүгд					үүнээс: шинээр тавьсан				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
<b>Бүгд</b>	<b>22.6</b>	<b>19.3</b>	<b>13.9</b>	<b>17.5</b>	<b>19.1</b>	<b>0.34</b>	<b>0.24</b>	<b>0.26</b>	<b>0.6</b>	<b>0.4</b>
Буур	0.26	0.24	0.25	0.3	0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
Азарга	2.5	2.3	2.0	2.1	2.2	0.02	0.0	0.0	0.0	0.008
Бух	1.7	1.4	1.2	1.5	1.6	0.01	0.01	0.01	0.02	0.01
Хуц	9.9	8.4	5.8	7.3	8.2	0.7	0.14	0.2	0.4	0.3
Ухна	8.3	6.9	4.7	6.3	6.8	0.09	0.1	0.05	0.1	0.08

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад 2012 онд аймгийн дунджаар 55 эм хонь, 55 эм ямаа ногдож, 2 дахин өндөр үзүүлэлт гарлаа. Энэ нь манай аймагт бог малын хувьд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо харьцангуй алдагдаж байгааг харуулж байна.

## Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

	Үржлийн норм	2008	2009	2010	2011	2012	Улсын дундаж
Ингэ	<b>20-25</b>	19	21	20	19	20	<b>27</b>
Гүү	<b>12-15</b>	9	10	11	9	9	<b>8</b>
Үнээ	<b>35-45</b>	28	31	39	28	28	<b>30</b>
Эм хонь	<b>25-30</b>	57	65	94	53	55	<b>66</b>
Эм ямаа	<b>25-30</b>	59	66	96	54	55	<b>69</b>

**Малын хэрэглээний зарлага.** 2012 онд оны эхний нийт малын 21.9 хувь буюу 401.7 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос тэмээ, адуу, үхэр 0.5 – 32.9 мянган толгойгоор өсч, харин хонь 46.1 мянган толгойгоор буурсан байна.

Манай аймагт малтай нэг өрх дунджаар 33 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна. Үүнийг аймгийн хэмжээний нийт өрхөөр тооцвол нэг өрх дунджаар 20 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

## Малын хэрэглээний зарлага

мян.тол

	2008	2009	2010	2011	2012
<b>Бүгд</b>	<b>610.5</b>	<b>558.1</b>	<b>369.8</b>	<b>406.3</b>	<b>401.7</b>
Тэмээ	1.8	1.6	1.4	0.9	1.4
Адуу	10.2	9.4	5.9	5.6	7.7
Үхэр	27.1	24.1	12.8	13.5	19.6
Хонь	344.2	298.1	217.7	236.9	190.8
Ямаа	227.1	224.8	132.0	149.3	182.2

Хэрэглээнд зарцуулсан малын 92.8 хувийг бог мал, 7.2 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхний тэмээний 9.0 хувь, адууны 12.0 хувь, үхрийн 20.4 хувь, хонины 22.4 хувь, ямааны 22.6 хувийг хэрэглээнд зарцуулсан байна.

**Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод  
хэрэглэсэн малын тоо мян.тол**


	Зах зээлд худалдан борлуулсан					Аж ахуйн дотоодод хэрэглэсэн				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
<b>Бүгд</b>	<b>147.7</b>	<b>149.5</b>	<b>136.8</b>	<b>118.3</b>	<b>147.7</b>	<b>184.3</b>	<b>178.3</b>	<b>160.5</b>	<b>135.7</b>	<b>157.6</b>
Тэмээ	0.3	0.3	0.3	0.5	0.5	0.3	0.4	0.3	0.3	0.3
Адуу	1.9	1.9	2.3	2.2	2.3	3.3	3.2	3.1	2.6	3.0
Үхэр	6.9	6.5	5.1	5.3	6.6	8.1	7.6	6.5	5.6	6.7
Хонь	79.0	83.0	76.7	67.1	73.7	99.4	92.0	85.0	71.6	76.9
Ямаа	59.6	57.8	52.4	43.3	64.6	73.2	75.0	65.6	55.6	70.7

Хэрэглээнд зарцуулсан малын 36.8 хувийг зах зээлд худалдан борлуулж, 39.2 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 26.4 хувь нь Баруун, 19.4 хувь нь Хойд бүсэд, 5.6 хувь нь Төвийн бүсэд, 25.8 хувь нь Зүүн бүсэд, 22.8 хувь нь Өмнөд бүсэд ногдож байна.

Малтай нэг өрх дунджаар 12 толгой малыг зах зээлд борлуулж, 13 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

Зураг 12



**Сүргийн бүтэц.** 2012 оны байдлаар нийт сүргийн 29.4 хувь буюу 596.0 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 25.5 хувь буюу 518.1 мянган толгой нь нас гүйцсэн мал, 44.2 хувь буюу 897.4 мянган толгой нь хээлтэгч мал, 0.9 хувь буюу 19.1 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

## Сүргийн бүтэц, 2012 онд

	Толгойгоор, мян.тол					Хувиар				
	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүү - лэгч	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүү лэгч
Бүгд	2030.77	596.0	518.1	897.4	19.1	100	29.3	25.5	44.2	0.9
Тэмээ	16.9	3.1	7.9	5.6	0.3	100	18.3	46.7	33.1	1.8
Адуу	70.4	11.4	36.7	20.1	2.2	100	16.2	52.1	28.6	3.1
үхэр	108.0	20.0	40.5	45.9	1.6	100	18.5	37.5	42.5	1.5
хонь	976.0	319.1	199.6	449.1	8.2	100	32.7	20.5	46.0	0.8
ямаа	859.3	242.4	233.4	376.7	6.8	100	28.2	27.2	43.8	0.8

Малын нас, хүйсээр нийт сүрэгт эзлэх хувийг өмнөх оныхтой харьцуулж авч үзэхэд 2012 оны байдлаар сүрэгт хээлтэгчийн эзлэх хувь 0.8 пункт, нас гүйцсэн эр малын эзлэх хувь 5.9 пунктээр тус тус өсч, төл өсвөр насны малын эзлэх хувь 6.7 пунктээр буурч, хээлтүүлэгчийн эзлэх хувь нь өмнөх түвшинд байна.

## Сүргийн бүтэц, хувиар

	Төл, өсвөр насны					Нас гүйцсэн эр				
	1966-1968*	2009	2010	2011	2012	1966-1968*	2009	2010	2011	2012
Бүгд	<b>34.7</b>	27.1	20.8	36.0	29.3	<b>15.6</b>	25.6	28.8	19.6	25.5
Тэмээ	<b>31.2</b>	27.6	24.8	13.0	18.3	<b>39.0</b>	39.0	40.0	51.3	46.7
Адуу	<b>31.6</b>	28.2	23.6	18.2	16.2	<b>37.7</b>	39.1	42.0	49.1	52.1
Үхэр	<b>46.5</b>	40.8	39.5	28.4	18.5	<b>9.2</b>	12.3	11.6	25.4	37.5
Хонь	<b>34.5</b>	29.3	23.2	38.9	32.7	<b>12.2</b>	22.0	24.6	14.5	20.5
Ямаа	<b>231.7</b>	22.9	15.4	35.7	28.2	<b>13.0</b>	30.0	33.6	21.3	27.2

үргэлжлэл

	Хээлтэгч					Хээлтүүлэгч				
	1966-1968*	2009	2010	2011	2012	1966-1968*	2009	2010	2011	2012
Бүгд	<b>48.2</b>	46.5	49.6	43.4	44.2	<b>1.5</b>	0.8	0.9	0.9	0.9
Тэмээ	<b>28.8</b>	31.8	33.8	33.8	33.1	<b>1.0</b>	1.5	1.4	1.9	1.8
Адуу	<b>27.9</b>	29.6	31.0	29.4	28.6	<b>2.8</b>	3.1	3.4	3.3	3.1
Үхэр	<b>42.5</b>	45.5	47.5	44.6	42.5	<b>1.8</b>	1.4	1.4	1.6	1.5
Хонь	<b>51.9</b>	48.0	51.2	45.7	46.0	<b>1.4</b>	0.7	0.7	0.9	0.8
Ямаа	<b>54.0</b>	46.4	50.0	42.2	43.8	<b>1.3</b>	0.7	0.7	0.8	0.8

\*жилийн дундаж

1966 – 1968 оны төлөвлөгөөт эдийн засгийн үеийнхтэй зэрэгцүүлж үзвэл сүргийн бүтцэд гарсан нэг томоохон өөрчлөлт нь бод болон бог малд эр сувай малын нөөцтэй болсон явдал юм. Бог малд эр сувай малын эзлэх хэмжээ 1966 – 1968 онд 12.2 – 13.0 хувь байсан бол 2012 онд 20.5 – 27.2 хувь болж бараг 2 дахин нэмэгджээ. Энэ хугацаанд бод малд эр сувай мал 9.2 – 39.0 хувь эзэлж байснаа 25.5 – 52.1 хувь болж нэмэгдсэн байна.

## II.2.3 МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ

**Бэлчээрийн хүрэлцээ.** Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2012 оны газрын нэгдмэл сангийн урьдчилсан тайлангаар манай аймгийн бэлчээр, хадлангийн талбай 4.4 сая га талбайд хүрч, өмнөх оны түвшинд байна.

2012 онд хонин толгойд шилжүүлснээр 2963.6 мянган толгой мал байгаа нь өнгөрсөн оноос 288.4 мянган толгойгоор өсч, 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 68 толгой мал ногдож байна.


Хүснэгт 29

### Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2008	2009	2010	2011	2012	$\frac{2012}{2011}$ %
Хадлан бэлчээрийн талбай, мян.га	4362.4	4362.3	4359.2	4359.2	4359.2	100.0
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	81	75	55	61	68	109.8

100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо өмнөх оныхоос 7 толгойгоор өсчээ.

2012 онд 100 га талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо нь улсын дунджаас 8 толгойгоор илүү байна. Энэ нь бэлчээрийн даацын хэтэрч байгааг харуулж байна.



**Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж.** 2012 онд аймгийн хэмжээгээр тэжээлийн нэгжид шилжүүлснээр 27.8 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 12.6 хувиар буюу 4 мянган тэжээлийн нэгжээр буурсан байна.

Хадлан бэлтгэлтийн хэмжээ Баруунтуруун, Бөхмөрөн, Зүүнговь, Наранбулаг, Өлгий, Тариалан, Түргэн сумдад өмнөх оныхоос 2.9 – 41.1 хувиар өсч, бусад сумдад 0.3 – 20.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 30

Бэлтгэсэн тэжээл, нэр т рл р /мян.тонн/

	2008	2009	2010	2011	2012	2011/2012%
Байгалийн хадлан	50.8	43.2	48	53.1	51.8	97.6
Сүрэл	0.7	0.8	0.7	3.2	0.4	12.5
Ногоон тэжээл	1.2	0.3	0.8	1.6	0.6	37.5
Гар тэжээл	2.9	1.8	1.6	2.5	1.9	76.0
Бэлтгэсэн дарш						
Эрдэс тэжээл	0.2	0.1	0.1	0.02	0.4	20.0
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд /тэж.нэгж/	32.2	25.7	27.4	31.8	27.8	87.4
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ноогдож буй тэжээл <b>аймагт</b>	9.2	7.9	11.5	11.9	9.4	79.0
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ноогдож буй тэжээл <b>улсад</b>	8.2	7.2	11.3	11.0	9.3	84.5

2012 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд улсын дунджаар 9,3 кг, аймгийн дунджаар 9.4 кг тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээл ногдож байгаа нь улсын дунджаас 0.1 кг-аар илүү байна.

#### II.2.4 ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2012 онд 115 гахай, 185 шувуу, 70 бүл зөгий тоологдсон ба өмнөх оныхоос гахайн тоо 56 толгойгоор өсч, шувуу 1394 толгойгоор, бүл зөгийн тоо 71 бүлээр тус тус буурсан байна. Хүснэгт

**Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо**

	2008	2009	2010	2011	2012	$\frac{2012}{2011}$ %
Гахай (тол)	110	47	62	59	115	194.9
Шувуу (тол)	147	128	277	1579	185	-11.7
Цаа буга						
Илжиг						
Зөгий (бүл)	71	84	111	141	70	-49.6
Туулай		2				

### II.2.6 Малжуулах арга хэмжээний талаарх мэдээлэл

Монгол Улсын засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2012 онд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах арга хэмжээнд зориулж 98.7 сая төгрөгийг зарцуулав. Малжуулах арга хэмжээ нь орон нутаг, гадаад улс орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага зэрэг олон төрлийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байна.

Хүснэгт 32

Он	Малжуулалтанд хамрагдсан		Нэг өрхийн ам бүлийн тоо	Малжуулалтаар авсан малын тоо, тол	Үүнээс		Малжуулалтаар авсан малд эзлэх хувь		малжуулалтад хамрагдсан 1 өрхөд ноогдох мал
	өрхийн тоо	Ам бүл			Бод мал	Бог мал	Бод мал	Бог мал	
2008	109	442	4	986	7	979	0.7	99.3	9
2009	62	293	5	1267	40	1227	3.2	96.8	20
2010	718	3210	4	18110	54	18056	0.3	99.7	25
2011	117	477	4	3343	16	3327	0.5	99.5	29
2012	43	191	4	1833	14	1819	0.8	99.2	43

2012 оны байдлаар аймгийн хэмжээнд 43 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдаж тэдэнд 1833 толгой мал олгож, 98.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. Малжуулалтын төсөлд хамрагдсан нэг өрх дунджаар 4 ам бүлтэй байв.

Нийт олгосон малын 99.2 хувь нь бог мал, 0.8 хувь нь бод мал байна. Нэг өрхөд дунджаар 42 толгой мал ноогдож байна.

Хүснэгт 33

